

УЛС ТӨРИЙН НАМ, СОНГУУЛИЙН ШИНЭЧЛЭЛИЙН ДАРААХ АСУУДЛУУД

НАМЫН ДОТООД АРДЧИЛАЛ, НЭР ДЭВШҮҮЛЭХ ПРОЦЕСС

Д.Энхцэцэг

Ардчилсан тогтолцоонд улс төрийн намууд нь иргэд сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдэж улс төрийн хүсэл зориг, үзэл бодлоо илэрхийлэх, улс төрийн эрх мэдэлд хүрэх, засаглалд оролцох гүүр болдог. Энэ утгаар харвал улс төрийн нам нь засгийн бүх эрх ард түмний мэдэлд байх Үндсэн хуулийн зарчмыг хэрэгжүүлэхэд нэн чухал үүрэгтэй ардчиллын институци билээ.

Монгол Улс нэг нам дангаар ноёрхсон тогтолцоог халж, шинэ ардчилсан Үндсэн хуульдаа Монгол Улсын иргэд “нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй” [...] болохыг тунхаглан баталгаажуулснаас хойш одоогийн байдлаар Улсын Дээд Шүүхэд 37 нам албан ёсоор бүртгүүлжээ. Гэсэн хэдий ч судлаачдын дүгнэснээр өнөөг хүртэл Монгол Улсад үнэт

зүйл, үзэл санааны хувьд нийтэд танигдан хүлээн зөвшөөрөгдөж, нийгэмд эзлэх байр суурь нь тогтворжсон, сонгогчидтой байнгын харилцаатай, байгууллагын зохион байгуулалт, процесс, төлөвшлийн хувьд институтчлэгдсэн нам тун цөөн байна (Касал Бертоа & А.Бат-Оргил, 2021). Өнгөрсөн хэд хэдэн парламентын сонгуульд эрх баригч нам парламентын үнэмлэхүй олонх болж нийт суудлын тавиас дээш хувийг бүрдүүлж ирсэн билээ. Үүнээс үндэслэн улс төр судлаачид Монгол Улсад нэг нам давамгайлсан систем тогтох шинж илэрч байгааг тэмдэглэх болсон (Э.Гэрэлт-Од, 2021). Нэг нам давамгайлсан систем ардчилсан тогтолцоотой улсуудад ердийн үзэгдэл боловч ардчилал нь харьцангуй шинэ болон өөр дэглэмтэй улсуудын дунд оршдог Монгол шиг улсуудын ардчилалд тийм ч таатай үзэгдэл биш болохыг Фиш тэргүүтэй судлаачид онцолсон байдаг (Фиш.С, Сибберг.М, 2017).



Д. ЭНХЦЭЦЭГ

ННФ-ын Засаглалын асуудлаар хэрэгжүүлж буй хөтөлбөрийг хариуцан ажилладаг. 2008 оноос хойших УИХ-ын болон Ерөнхийлөгчийн сонгуулиудад иргэний нийгмийн зүгээс хийсэн хяналт, мониторингийн ажилд арга зүйн туслалцаа үзүүлэн, удирдан ажилласан бөгөөд энэхүү ажиглалтууддаа тулгуурлан сонгуулийн үйл явцыг боловсронгуй болгох чиглэлээр харьцуулсан судалгаа шинжилгээ хийхэд түлхүү анхааран ажиллаж байна.

Тэрбээр МУИС-ын Олон улсын харилцааны дээд сургууль, Унгар дахь Төв Европын Их Сургууль, АНУ-ын Хавайн Их Сургууль болон Австралийн Сиднейн Их Сургуулийн Хуулийн сургуульд нийтийн удирдлага, захиргааны эрх зүй, нийтийн бодлогын чиглэлээр суралцаж төгсжээ.

Намын системийн өнөөгийн төлөв байдал бүрэлдэхэд сонгуулийн тогтолцоо, улс төрийн санхүүжилт гэх мэт янз бүрийн хүчин зүйл нөлөөлж ирсэн нь гарцаагүй боловч улс төрийн намын доторх манлайлал, дотоод ардчилал хангалтгүй байгаа нь ч нөлөөлж буй билээ. Үүнээс үүдэн сүүлийн жилүүдэд улс төрийн намтай холбоотой эрх зүйн орчинд хэд хэдэн удаагийн томоохон шинэчлэл хийгдэв.

График 1: 1992 оноос хойших УИХ-ын сонгуулиудын дүн



Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хороо
www.gec.gov.mn

Юуны түрүүнд, 2019 онд Үндсэн хуульд туссан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд “Намын дотоод зохион байгуулалт ардчилсан зарчимд нийцсэн, хөрөнгө орлогын эх үүсвэр, зарцуулалт нь нийтэд ил тод байна. Намын зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, санхүүжилт, төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөлийг хуулиар тогтооно” гэж тусгасан (МУҮХ-ийн 19). Түүнчлэн 2023 онд Үндсэн хуульд дахин нэг өөрчлөлт нэмэгдсэн нь “Улсын Их

Хурал нэг танхимтай, нэг зуун хорин зургаан гишүүнтэй байна. Улсын Их Хурлын сонгуулийг сонгуулийн холимог тогтолцоогоор явуулна. Улсын Их Хурлын далан найман гишүүнийг олныг төлөөлөх, дөчин найман гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгоно” гэжээ (МУҮХ 21.1).

Үндсэн хуульд туссан дээрх өөрчлөлтийн хүрээнд 2023 онд УИХ-аас Улс төрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга болон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг тус тус баталсан. Шинээр баталсан Улс төрийн намын тухай хуульд намын дотоод ардчилалыг бүрэлдүүлж сахихад шаардлагатай бүтэц, дүрэмд заавал тусгах асуудлыг зааснаас гадна төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг зөвхөн парламентад суудалтай намуудаар хязгаарлахгүй сонгуулийн амжилтад нь үндэслэн олгох зохицуулалтууд багтжээ. УИХ-ын сонгуулийн хуулийн тухайд холимог тогтолцоогоор сонгуулийг зохион байгуулах асуудлыг нарийвчлан зохицуулсны дотор хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгох 48 суудлын төлөө өрсөлдөх намын жагсаалтын нэр дэвшигчдийг 1:1 хүйсийн харьцаатай байх шаардлагыг тусгасан байна.

2024 оны УИХ-ын ээлжит сонгууль хаянд ирээд буй энэ үед эрх зүйн орчинд хийгдсэн эдгээр шинэчлэл нь ямар бодитой үр дүн үзүүлэх вэ гэсэн асуулт зүй ёсоор тавигдана. Ялангуяа, УИХ-ын суудлын тоо 65 хувиар нэмэгдсэнтэй холбоотой холимог тогтолцоогоор явагдах сонгуулиар шинээр бүрдэх парламент нь чадварлаг, ёс зүйтэй, нийтийн итгэлийг хөсөрдүүлэлгүй ажиллах бүрэлдэхүүн байж чадах уу? Үүний баталгааг хангаж улс төр дэх мөнгөний зүй бус нөлөөнөөс ангид, олны итгэл хүлээх чансаатай нэр дэвшигчид сонгуульд өрсөлдөх баталгаа бий юу? гэсэн асуулт урган гарч байна.

Эрх зүйн шинэчлэлийн хүрээнд дээрх асуултуудтай холбоотой зарим зохицуулалт хуулиудад туссан байх боловч хуулийн хэрэгжилтийг хангаж, бодитой үр дүнд хүргэхэд гол үүрэг гүйцэтгэх тал нь гарцаагүй улс төрийн намууд өөрсдөө билээ. Ялангуяа дотоод ардчиллыг хангах, үүний дотор намын дотоод сонгууль гэх мэт асуудал нь намын дүрэм, зохион байгуулалттай шууд холбоотой тул хуулиар нарийвчлан зохицуулах боломжгүй бөгөөд олон улсын стандартыг авч үзвэл чингэх нь угаасаа зохимжгүй юм.¹ Энэ нөхцөлд хуулиар тогтоосон ерөнхий зарчим, зарим тодорхой шаардлагын хүрээнд улс төрийн намууд өөрсдөө юуны түрүүнд манлайлал үзүүлж, дотоод ардчилалтай холбоотой асуудлуудаа олон улсын чиг хандлага, сайн туршлагад дөхүүлэн шинэчлэх нь хэтдээ намын төлөвшил, системийн хөгжилд сайн нөлөө үзүүлнэ гэж үзэж байна.

Улс төрийн судалгааны Европын консорциумын тодорхойлсноор

Улс төрийн намын дотоод ардчиллын асуудалд зайлшгүй хамаарах хэд хэдэн зүйл байна. Үүнд намын бүтэц, зохион байгуулалтыг тодорхойлсон дүрэм нэн тэргүүнд багтана. Эдгээр дүрэм нь ил тод, намын гишүүдэд ойлгомжтой бөгөөд зөвхөн тогтсон дүрмийн дагуу өөрчлөх боломжтой байх нь зүйд нийцнэ. Намын удирдлагыг сонгуулиар сонгодог байх ёстой. Түүнчлэн, сонгуульд өрсөлдөх нэр дэвшигчийг зөвхөн намын дарга ганцаараа биш, тодорхой хүрээнд хамтын шийдвэрт тулгуурлах нь зүйтэй (2024).

Намын дотоод ардчиллын асуудлыг судлаачид авч үзэхдээ юуны түрүүнд намын удирдлага, нэр дэвшигчдийг тодруулж сонгох процесс, намын хөтөлбөр, бодлогын байр суурийг тодорхойлох үйл явц, эдгээрт 1) гишүүдийн болон бусад талын оролцоог ямар түвшинд хангаж буй, 2) шийдвэр гаргах тогтолцооны төвлөрсөн байдал болон 3) институтчлэл хэрхэн хангагдаж байгааг шинжилж үздэг (Үндэсний ардчиллын хүрээлэн, 2005). Үүнд:

Нээлттэй, оролцоо хангасан байдал:

Шийдвэрээс өмнөх процесс буюу намын гишүүд, дэмжигчид, бусад оролцогч талуудыг сонсох, зөвшилцөх, шийдвэр гаргахад тэдний ямар жин дардаг болохыг энэ хэмжүүрээр дүгнэнэ. Оролцоо туйлын хязгаарлагдмал нөхцөлд нэг буюу нэг хэсэг удирдагчдын хүрээнд чухал шийдвэрүүд гарах ба бусад тал оролцох боломжгүй.

Төвлөрсөн байдал: Шийдвэр ямар хүрээнд гарч байгааг энд авч үзнэ. Төвлөрсөн удирдлагатай намын гүйцэтгэх төв байгууллага нь гол шийдвэрүүдийг гаргаж, нам нь хүлээн авч дагадаг.

Институтчлэл: шийдвэр гаргах үйл явцыг журамлаж, албан ёсны болгон зохицуулсан байдал болон тэдгээрийг дагаж мөрдөх тогтолцоог үүнд хамруулан үзнэ.

Энэхүү нийтлэлд намын дотоод ардчилалтай холбоотой нэр дэвшигчийг тодруулах үйл явцыг онцлон Улс төрийн намын тухай хууль болон УИХ-ын сонгуулийн тухай хуульд туссан зохицуулалт, сонгуульд өрсөлдөх нэр дэвшигчдээ тодруулахад намуудын дагаж ирсэн процесс, олон улсын туршлага зэргийг танилцуулж, тэдгээрт үндэслэн тодорхой зөвлөмж санал болгоно.

¹ Улс төрийн нам нь сонгуулиар дамжуулж төрийн эрх барих мандат олж авдаг онцгой үүрэг бүхий институци мөн боловч, нөгөө талаар иргэдийн сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдсэн байгууллага болно. Тиймээс Венецийн комиссоос гаргасан Улс төрийн намын тухай хууль тогтоомжийг боловсруулах удирдамжид улс төрийн намын тухай хуульд намын дотоод асуудалд хэт гүнзгий оролцсон зохицуулалт байх нь зохимжгүй болохыг дурдсан байдаг.

ХУУЛЬ ТОГТООМЖИД ТУССАН ЗОХИЦУУЛАЛТ

Төлөөллийн ардчиллын процессын хувьд нэр дэвшүүлэх үйл ажиллагаа нь сонгуулийн тогтолцоотой ижил ач холбогдолтой бөгөөд намуудын зүгээс ардчилалд оруулах нэг хэлбэрийн хувь нэмэр болохыг улс төр судлаач эрдэмтэд онцолсон байдаг (Рахат.Г, 2023).

Нэр дэвшигчдээ тодруулах сонгууль буюу процесс нь намын дотоод үйл ажиллагаа тул хуулиар нарийвчлан зохицуулах нь ховор байна. Улс орнуудын туршлагыг харахад хуульд ихэвчлэн нэр дэвшигчдэд тавих зарим шалгуур, нэр дэвшигчдийг тодруулахад баримтлах ерөнхий зарчмыг заахаас хэтэрдэггүй.

2023 оны Улс төрийн намын тухай хууль болон нэмэлт, өөрчлөлт оруулсан УИХ-ын сонгуулийн хуулиудыг харьцуулж үзэхэд нэр дэвшүүлэхэд баримтлах ерөнхий зарчим, нэр дэвшигчдэд тавих бусад шаардлага болон төлөөллийг хангах, шийдвэр гаргах болон зохион байгуулалттай холбоотой хэд хэдэн ерөнхий зохицуулалт тусгагджээ. Хуулийн хүрээнд ардчилсан зарчимд нийцүүлэн нэр дэвшигчдийг тодруулах үйл ажиллагааны дүрэм гаргаж, хэрэгжүүлэх нь намуудын санаачилгаас голлон хамаарахаар байна.

Улс төрийн намын тухай хуулийн 15.2.8 дахь хэсэгт нам дүрэмдээ “төрийн улс төрийн албан тушаалд болон намын удирдах албан тушаалд нэр дэвшигчийг сонгох, томилох, чөлөөлөх, тэдгээрт жендэрийн тэгш байдлыг хангах журам”-аа

тусгаж батлах шаардлагатайг заажээ. Уг хуулийн дагуу намын дүрмийг батлах нь улс төрийн намын удирдах дээд байгууллагын онцгой бүрэн эрхэд хамаарах асуудал байна /17.2.1/. Мөн хуулийн 17.4-т “Намын төлөөллийн төв байгууллагын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь санал гаргавал намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж болно. Энэ нэмэлт, өөрчлөлт нь намын дүрмийн гуравны нэгээс хэтрэхгүй байна” гэжээ. Эндээс үзэхэд нам төрийн сонгуульд оролцох нэр дэвшигчидээ тодруулах журам нь дотоод ардчиллын чухал асуудал тул гишүүдийнхээ өргөн оролцоотой хэлэлцэж шийдвэрлэх байдлаар зохицуулжээ.

Үүнээс гадна УИХ-ын сонгуулийн хуульд сонгуульд оролцох нам, эвсэл хүсэлтээ Сонгуулийн ерөнхий хороо (СЕХ)-нд хүргүүлэхдээ хуульд заасан шаардлагад нийцсэн нэр дэвшүүлэх ажиллагааны талаарх намын дотоод журам” заавал хавсаргахаар заасан байна /26.3.5/². Иймд сонгуульд оролцох бэлтгэлээ базааж буй намууд 2024 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн хэрэгжиж буй Улс төрийн намын тухай хууль болон сонгуулийн хуульд сонгуульд нэр дэвшүүлэх үйл ажиллагааг нарийвчлан зохицуулсан дотоод дүрмээ нийцүүлэн батлах нь нэн түрүүнд анхаарвал зохих асуудал болоод байна. Дээр дурдсан хуулиудад туссан нэр дэвшигчдийг тодруулах процесстэй холбоотой зохицуулалтыг харьцсныг хүснэгт 1-ээс үзнэ үү:

² Хүснэгтэд байгаа шаардлагуудаас гадна нэр дэвшигч нь төрийн жинхэнэ албан хаагч, төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн дарга, дэд дарга, захирал, дэд захирлын ажил, албан тушаал эрхэлж байгаа бол сонгуулийн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө эрхэлсэн ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдсөн байхыг хуулиар шаарддаг /МУИХСтХ 29.4/. Сонгуульд эвсэл болж нэгдэн оролцож байгаа намуудын хувьд хуулийн 27.2.-д зааснаар “Эвсэлд нэгдэж байгаа намын Их хурал, эсхүл төлөөллийн төв байгууллага нь нэр дэвшүүлэх асуудлыг нууц санал хураалтаар шийдвэрлэнэ” гэжээ.

Хүснэгт 1. Нэр дэвшигчдийг тодруулахтай холбоотой зохицуулалт

Улс төрийн намын тухай хууль /2023 он/	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль /2019 онд баталж, 2023 онд нэмэлт, өөрчлөлт тусгасан/
---	--

Нэр дэвшигчдийг тодруулахад баримтлах ерөнхий зарчим, шаардлага

- Нам гишүүдээ намын удирдах байгууллага, албан тушаал, сонгуульд нэр дэвших, сонгох, томилоход аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахгүй байж, тэгш боломж олгоно /8.1/
- Намын дүрэм, хөтөлбөрийг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах болон сонгуульд нэр дэвшигчийг санал болгоход намын гишүүдийн оролцоог хангаж, саналыг сонсоно /8.4/
- Нам, эвсэл нэр дэвшүүлэхдээ ардчилсан ёс, шударга ёсны зарчмыг баримталж, нийгмийн бүлгийн төлөөллийг харгалзана /29.10/
- 25 насанд хүрсэн, сонгуулийн эрх бүхий, энэ хуульд заасан шаардлагыг хангасан Монгол Улсын иргэн Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдох эрхтэй /5.3./
- Нам, эвсэл нь 78 хүртэл хүнийг энэ хуульд заасны дагуу байгуулагдсан сонгуулийн тойрогт, 48 хүртэл хүнийг нам, эвслийн нэр дэвшигчдийн жагсаалтаар тус тус нэр дэвшүүлнэ /30.1/

Нам бодлого, үйл ажиллагаандаа хувь хүн болон нийгмийн бүлгийг аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахыг хориглоно /8.6/

Шийдвэр гаргах болон зохион байгуулалттай холбоотой зохицуулалт

Нам Монгол Улсын Их Хурлын сонгуульд намаас нэр дэвшигчийг сонгох ажлыг зохион байгуулах хороотой байж болно. Хорооны бүрэлдэхүүнд тавих шаардлага, түүнийг байгуулах, ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах болон үйл ажиллагааны журмыг энэ хуулийн 8 дугаар зүйл, намын дүрэмд нийцүүлнэ /19.4./

30.5. Намаас нэр дэвшүүлэх асуудлыг тухайн намын Их хурал, эсхүл төлөөллийн төв байгууллага хуралдаанаараа хэлэлцэж, нууцаар санал хурааж, олонхын саналаар шийдвэрлэнэ

Хориглосон зохицуулалт

- Нам дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:
- хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол зэргээр нь ялгаварлан гадуурхах /10.1.4./
 - сонгуульд нэр дэвших эрх олгохдоо намын гишүүн, дэмжигчээсээ барьцаа, дэнчин болон бусад аливаа хэлбэрээр мөнгө болон мөнгөн бус хөрөнгө, үйлчилгээ өгөхийг шаардах, авах /10.1.6./
 - Нэг намын гишүүнийг өөр намаас, эвслийн тухайд түүнд нэгдэн орсон намуудаас өөр намын гишүүнийг нэр дэвшүүлэхийг хориглоно /29.5/
 - Нэр дэвшигч нь нэгээс илүү тойрогт нэр дэвшихийг хориглоно /29.6/
 - Гэмт хэрэг үйлдэж шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор ял эдэлж байгаа хүн нэр дэвшихийг хориглоно /29.8./
 - Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон бол нэр дэвшихийг хориглоно /29.9./
 - Нам, эвсэл нэр дэвшүүлэхдээ намын гишүүн, дэмжигчээсээ мөнгөн болон мөнгөн бус хөрөнгө, үйлчилгээ, барьцаа, дэнчин авахыг хориглоно /30.3/

Нэр дэвшигчдэд тавих бусад шаардлага болон төлөөллийг хангахтай холбоотой зохицуулалт

- Нэр дэвшүүлэхэд аль нэг хүйсийн төлөөлөл 30 хувиас доошгүй байна /8.2.3./
- Нэр дэвшигч хуульд заасан нийтлэг шаардлагаас гадна дараах шаардлагыг хангасан байна /29.3./: банк, бусад хуулийн этгээд, иргэнд шүүх болон арбитрын шийдвэрээр тогтоогдсон төлбөл зохих зээл, барьцаа болон батлан даалтын өр төлбөргүй байх /29.3.1/ татварын хугацаа хэтэрсэн өр төлбөргүй байх, аль нэг компанийн 51, түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшдэг бол тухайн компани нь албан татварын хугацаа хэтэрсэн өргүй байх /29.3.2/ сүүлийн 6 хүртэл жилийн хугацаанд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлд гишүүнээр ажиллаж байгаагүй /29.3.3/³
 - Нам, эвслээс нэр дэвшүүлэхэд 2024 оны ээлжит сонгуулиар нийт нэр дэвшигчийн 30-аас доошгүй хувь нь, 2028 оны ээлжит сонгуулиар 40-өөс доошгүй хувь нь аль нэг хүйсийнх байна /30.2/
 - Нам, эвсэл жагсаалтаар нэр дэвшүүлэхдээ 1:1 хүйсийн харьцаатай жагсаалтын дарааллыг үндэслэн нэр дэвшүүлнэ /30.6/

³ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 1-р сарын 17-ны дунд суудлын хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.3 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хэлэлцээд Үндсэн хууль зөрчсөн гэсэн дүгнэлт гаргажээ.

Сонгуульд нэр дэвшигчдийг тодруулах процесс нь хугацаа шаардах улс төрийн чухал шийдвэр бөгөөд холбогдох журмын хүрээнд тодорхой шаардлага хангах, нэр дэвших боломжтой гишүүдийн жагсаалт үүсгэх, сонгон шалгаруулах, хэн нэр дэвшихийг эцэслэн шийдэх, тойрогт хуваарилах, намын жагсаалтад эрэмбэлэх зэрэг олон чухал асуудлыг тусгах шаардлагатай.

Товчхондоо намын зорилго болон тактик, процессын шинэчлэлтэй уялдах тухай асуудал энд хөндөгдөнө. Нэг талаас нэр дэвшигчдийн талаарх шийдвэр нь намын сонгуулийн ерөнхий стратегийн хүрээний асуудал мөн. Нөгөө талаас шийдвэр гаргах үйл явц нь Үндсэн хуульд заасан

намын дотоод үйл ажиллагаа ардчилсан зарчимд нийцсэн байх шаардлагыг хангах нь туйлын чухал юм.

2019 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийг даган шинэчлэгдэж буй эрх зүйн орчны хүрээнд нам дүрмээ батлах, шинэчлэх нь амаргүй ажил боловч намуудын хувьд өмнөх туршлага, алдаа, оноогоо цэгнэн дотоод зохион байгуулалт, үйл ажиллагаа, түүний дотор төрийн сонгуульд өрсөлдөх нэр дэвшигчдээ тодруулах үйл явцыг ардчилсан зарчим, олон улсын сайн туршлага, улс төрийн намуудын хөгжлийн чиг хандлагад нийцүүлэх нэг боломж юм.

ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛИЙН ӨМНӨХ НӨХЦӨЛ БАЙДАЛ, ЦААШИД АНХААРАХ АСУУДЛУУД

Хуулиуд шинэчлэгдэхээс өмнө одоогийн парламентад суудалтай зарим нам сонгуульд нэр дэвшигчдийг тодруулах журмаа хэрхэн баталж мөрдөж ирсэн туршлагыг судалж үзвэл процессыг албан ёсны журмаар зохицуулж, хэрэгжүүлэх бүтэц бий болгон институтчлэх санаачилга гаргаж ирсэн нь харагдана. Гэвч процесс нь гишүүдийн оролцоог хангахад чиглээгүй, нээлттэй, ил тод

биш байхын сацуу бодит байдалд журмаа дагаж мөрдөхгүй байх, шийдвэрийг цөөн нөлөө бүхий этгээдийн хүрээнд хэт хаалттай гаргадаг болох нь харагдана.

УИХ-д суудал бүхий намууд 2020 оны УИХ-ын сонгуульд оролцохоор СЕХ-нд бүртгүүлэхдээ нэр дэвшигчдээ тодруулах журмаа хавсаргасныг харьцуулж үзэв.

Монгол ардын нам (МАН)

Тус намын “УИХ-ын сонгуульд нэр дэвшүүлэх, санал хураалт явуулах, дүн гаргах журам”-д заасны дагуу нэр дэвших сонирхол бүхий намын гишүүн нь Удирдах Зөвлөлд саналаа бичгээр гаргана.⁴ Удирдах зөвлөлийн хувьд шийдвэр гаргахад нэр дэвшихээр хүсэлт гаргасан намын гишүүний холбогдох тойрогт явуулсан “социологийн судалгааны дүн, орон нутгийн намын байгууллага, гишүүдийн саналыг” харгалзах бөгөөд нэр дэвшигчдийн талаарх бодлогын шийдвэрээ Бага хуралдаа танилцуулан хэлэлцүүлж шийдвэр гаргуулна гэж зохицуулжээ. Түүнчлэн нэг мандатын төлөө хоёр болон түүнээс дээш нэр дэвших, Удирдах зөвлөлийн тодруулсан нэр дэвшигчээс өөр гишүүнийг Бага хурлаас санал болгох тохиолдолд Бага хурал нь нууцаар санал хурааж шийдвэрлэхээр зохицуулсан байна (МАН, 2020).

⁴ МАН-ын Бага хурлын 2020 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан

Ардчилсан нам (АН)

АН төрийн болон намын бүх шатны сонгуулийг зохион байгуулах үүрэгтэй Төрийн сонгууль зохион байгуулах байгууллага (энэ нь Сонгон шалгаруулах хороо, Тойргийн зөвлөл, Сонгуулийн штабаас бүрдэнэ), Дотоод сонгууль зохион байгуулах хоёр байгууллагатай.

- Сонгон шалгаруулах хороо нь намаас төрийн сонгуульд нэр дэвшигчдийг Үндсэн дүрэм, бусад журмын хүрээнд тодруулж шийдвэр гаргах эрх бүхий байгууллага буюу Үндэсний Бодлогын Хороо (ҮБХ)-д уламжлах, шаардлагатай тохиолдолд нэр дэвшигчидтэй холбоотой тухайн тойргийн нийт гишүүдийн дунд санал хураалт явуулах тухай санал гаргах чиг үүрэгтэй.
- Тойргийн зөвлөл нь төрийн сонгуульд амжилттай оролцох бэлтгэл хангах, кампанит ажлыг зохион байгуулах, төрийн сонгуульд тухайн тойргоос нэр дэвших хүсэлтэй, боломжтой гишүүдийн жагсаалтыг сонгон шалгаруулах хороонд хүргүүлэх, тойрог дахь намын гишүүдийн хүрээнд хэлэлцүүлэг, санал хураалт явуулах үүрэгтэй.
- Дотоод сонгуулийн хороо нь Намын Их Хурлын төлөөлөгч, Намын дарга, ҮБХ-ны гишүүн, нийслэл, аймаг, дүүргийн намын даргын сонгууль, Ерөнхийлөгч, УИХ-ын сонгуульд нэр дэвшигчийг тодруулах сонгуулийг, түүний салбар байгууллага болох Сонгуулийн нутаг дэвсгэрийн хороо, Сонгуулийн хэсгийн хороо нь нийслэл, дунд, анхан шатны намын хорооны гишүүн, нийслэл, аймаг, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд нэр дэвшигчийг сонгох сонгуулийг Үндсэн дүрэм, бусад журмын дагуу зохион байгуулж, дүнг нэгтгэн мэдээлэх, журамд заасан хугацаанд багтаан эрх бүхий байгууллагад өргөн мэдүүлэх чиг үүрэгтэй байгууллага ажээ.

Тус намын 2020 оны УИХ-ын сонгуульд оролцох нэр дэвшигчдийг тодруулсан журамд нэр дэвшигчдэд тавигдах шалгуурыг дараах байдлаар тусгажээ. Үүнд:

- УИХ-ын сонгуулийн нэр дэвшигч нь Үндэсний бодлогын хорооны гишүүн байна /2.1/. Үндсэн дүрмийн хороо, Дотоод сонгуулийн хорооны гишүүн нь мөн УИХ-ын сонгуульд нэр дэвших эрхтэй бөгөөд Сонгон шалгаруулах хороо (СоШХ)-нд нэр дэвших саналаа бичгээр гаргана гэж тусгажээ /2.2/. Дүрмийн 2.4.1-т “сонгуульд гишүүний татвараа төлөөгүй” намын гишүүнийг тухайн шатны сонгуульд нэр дэвшүүлэхгүй гэсэн байна.
- СоШХ нь нэр дэвшигчийг сонгон шалгаруулахдаа дараах нэмэлт үзүүлэлтийг харгалзан үзэхээр дүрмийн 3.10-т заасан байна. Үүнд:
 - Намын гишүүд болон анхан, дунд шатны намын байгууллагатай ажилласан байдал.
 - Иргэд сонгогчидтой ажилласан байдал.
 - Намын эрх бүхий байгууллагаас тогтоосон татварыг хугацаанд нь төлсөн эсэх.

Түүнчлэн “эмэгтэй нэр дэвшигчдийг тодруулахдаа Ардчилсан эмэгтэйчүүдийн холбооны Удирдах зөвлөлийн саналыг харгалзан үзнэ” гэжээ.

Нэр дэвшигчийг нөхөн нэр дэвшүүлэх нөхцөл үүссэн дараах тохиолдолд Намын дарга нь ҮБХ-ны хуралдаанд нэр дэвшигчийг нөхөн нэр дэвшүүлэх асуудлыг оруулж шийдвэрлүүлнэ /3.13/. Үүнд:

- Тухайн тойргийн мандатын тооноос дутуу нэр дэвшигчтэй
- Нэр дэвшигч нь нэрээ татсан
- Нэр дэвшигч нь олонхын санал аваагүй
- Нэр дэвшигчийн татвар /дэнчин/-ыг хугацаанд төлөөгүй
- Төрийн сонгуулийн байгууллагаас нэр дэвшигчийг бүртгээгүй, эсхүл бүртгэлийг хүчингүйд тооцсон

УИХ, ИТХ-ын сонгуульд нэр дэвшүүлэх Намын эрх бүхий байгууллагын хуралдааныг зарлаж хуралдуулах цаг хугацааны хувьд боломжгүй тухай дүгнэлтийг намын зохих шатны хяналтын байгууллага гаргасан тохиолдолд нэр дэвшүүлэх эрх зохих шатны намын даргад, нэр дэвшилтийг баталгаажуулах эрх намын гүйцэтгэх байгууллага (Улс төрийн зөвлөл, Намын хорооны тэргүүлэгчид)-д шилжинэ (АН, 2020).

ХҮН нам

ХҮН нам Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль, УИХ-ын сонгуульд нэр дэвшигчдийг Төлөөлөх зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэдэг байна. Судалгааны хүрээнд 2020 оны УИХ-ын сонгуульд оролцсон намуудын СЕХ-нд хүргүүлсэн нэр дэвшүүлэх журмыг үзэхэд “Зөв хүн электорат эвсэл” байгуулж оролцсон бөгөөд эвслийн төлөөлөх зөвлөлөөс 2020 оны 4-р сарын 23-нд баталсан нэр дэвшүүлэх дотоод журмыг үзвэл 4.2 дахь хэсэгт “Эвсэлд нэгдсэн намууд тус бүр өөрийн Намын дүрэм болон нэр дэвшүүлэх дотоод журмын дагуу эвслийн гэрээнд заасан тооны хүнийг өөрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр нэр дэвшүүлэх ажиллагаа эхлүүлэх хуульд заасан хугацаа эхлэх өдөр эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагад ирүүлнэ” гэжээ. Үүнээс өөр нэр дэвшигчдийг нам дотооддоо хэрхэн сонгон шалгаруулах, ямар шалгуурууд тавих, шийдвэр хэрхэн гаргах талаар нарийвчилсан зохицуулалт байхгүй байна.

Парламентад суудал бүхий дээрх намуудын нэр дэвшүүлэх дотоод журмуудад намын гишүүдийн оролцоог тодорхой түвшинд хангаж төлөөллийн төв байгууллагын оролцоотой шийдвэр гаргахаар зохицуулсан байх боловч бодит байдалд нэр дэвшүүлэх шийдвэрийг цөөн хүний хүрээнд, намын дарга голлох үүрэгтэй гаргадаг болохыг судалгаанд дурдсан байдаг (Цогц хөгжлийн үндэсний төв, 2021).

Намын гишүүдийн ярилцлагаас:

Дүрэм журмаа бидэнд өгдөггүй. Хурал дээр дэлгэцээр харуулдаг ч уншиж тунгаах боломж олгодоггүй.

Дүрэм журам гэдэг зүйл хэрэгжинэ. Гэхдээ 100 хувь хэрэгжүүлдэг гэвэл мэдээж үгүй. Тэгээд тэр дунд нөгөө л тодорхой санхүүтэй гэдэг юм уу, мөнгөний боломжтой тийм хүмүүс [...] хүч түрэн орж ирэх зүйл ажиглагддаг.

Намын хороон дээр хэлэлцүүлэг болсон. Дарга индэр дээрээс дээш нь уламжлах хүний нэрийг уншсан. Тэгээд л болоо. Юун ардчилал, хэлэлцэх тийм юм болоогүй.⁵

Ардчилсан тогтолцоонд улс төрийн намын гүйцэтгэх гол үүргийн нэг нь төлөөллийн үүрэг гэж үзвэл түүнд шууд хамаатай нэр дэвшүүлэх

журам гишүүддээ төдийгүй, олон нийтэд ойлгомжтой тодорхой байх учиртай. Дээр дурдсан намуудын нэр дэвшигчдээ тодруулах процессыг үзэхэд намын анхан шатны нэгж, гишүүдийн оролцоог хангахад анхаарсан мэт харагдавч бодит байдалд хэрэгжилтийг үр дүнтэй, маргаангүй зохион байгуулахад төвөгтэй, нарийвчлан зохицуулаагүй байна. Тухайлбал, МАН-ын хувьд намын анхан шатны байгууллагын түвшинд хэлэлцүүлэг явуулах нь Удирдах зөвлөлийн гаргах шийдвэрт ямар үүрэг нөлөөтэй нь ойлгомжгүй. Түүнчлэн, нэр дэвшигч заавал социологийн судалгаа явуулах, түүний дүнг Удирдах зөвлөл шийдвэр гаргахдаа харгалзаж үзэхээр заасан нь судалгааны аргачлалын хувьд ямар байхыг тухайн хүн үзэмжээр шийдэж болох мэт, энэ утгаараа шийдвэр гаргахад найдвартай үндэслэл болох эсэх нь эргэлзээтэй байна. Сонгуулийн тойргийн хэмжээнд судалгаа явуулах нь тухайн тойргийн цар хүрээнээс хамаараад нэлээд зардал шаардах ажил юм. Энэ зардлыг намын гишүүн өөрөө хариуцах нөхцөлд хувь хүнээс өндөр зардал шаардах ба одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй хуулиудын хүрээнд сонгуулийн ийм төрлийн санхүүжилтийг тооцож хянах боломжгүй.

АН төвлөрсөн бус байдлаар дотоод сонгуулийг зохион байгуулах тусгайлсан бүтэцтэй боловч

⁵ Цогц хөгжлийн үндэсний төв ТББ-аас 2020 оны УИХ-ын сонгуулийн дараа парламентад суудалтай намын гишүүдтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс (2021 он <https://www.uih.mn/sudalгаа/s/72>)

тухайн бүтцийн нэгж нь нэр дэвшигчдийг тодруулах процессыг ардчилсан зарчимд нийцүүлэн хэрхэн зохион байгуулдаг нь тодорхой биш байх аж. Тухайлбал, Сонгон шалгаруулах хороо нь “шаардлагатай тохиолдолд тухайн тойргийн нийт гишүүдийн дунд санал хураалт явуулах,” Тойргийн зөвлөл нь “төрийн сонгуульд тухайн тойргоос нэр дэвших хүсэлтэй, боломжтой гишүүдийн жагсаалтыг сонгон шалгаруулах хороонд хүргүүлэх, тойрог дахь намын гишүүдийн хүрээнд хэлэлцүүлэг, санал хураалт явуулах” гэх мэтээр зохион байгуулахаар байгаа нь цөөн нөлөө бүхий хүний хүрээнд төвлөрсөн байдлаар шийдвэр гарах нөхцөлийг бүрдүүлсэн харагдаж байна. Түүнчлэн сонгуульд оролцох зардлыг гишүүдээсээ татаж бүрдүүлэхээр заажээ.

2023 онд батлагдсан Улс төрийн намын тухай хууль болон сонгуулийн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр нам, эвсэл нэр дэвшүүлэхдээ намын гишүүн, дэмжигчээсээ мөнгөн болон мөнгөн бус хөрөнгө, үйлчилгээ, барьцаа, дэнчин авахыг хориглосон. Энэ нь улс төрийн санхүүжилтийн тогтолцооны гажуудлаас үүдэлтэй нэр дэвшигчдэд нэн тэргүүнд тавигддаг далд шалгуур буюу мөнгөний босгыг арилгахад чиглэсэн зохицуулалт юм.

Улс төрийн санхүүжилтийн одоогийн практикт тулгамдаж буй гол асуудлын нэг нь гарцаагүй сонгуульд нэр дэвших хүмүүсээс татдаг дэнчингийн хэмжээ огцом нэмэгдэж ирсэн явдал юм [...] Энэ практик нь сонгуулийн пассив эрх буюу сонгуульд нэр дэвших бололцоог зөрчихийн зэрэгцээ эдийн засгийн нөөц бололцоо хомс эмэгтэйчүүд, залуучуудын нэр дэвших бололцоог хязгаарлах сөрөг нөлөөтэйн дээр хуулиар тогтоосон хандивын хязгаарыг зөрчиж байна. (Бурчер.К & Касал Бертоа)

Улс төрийн санхүүжилтийн эх үүсвэрт төрийн санхүүжилтийн эзлэх хувийг хуулийн шинэчлэлийн хүрээнд нэмэгдүүлсэн нь аажимдаа дээрх асуудлыг шийдвэрлэхэд нөлөө үзүүлэх магадлалтай ч УИХ-аас шинэчлэн баталсан Улс

төрийн намын тухай хууль дөнгөж 2024 оноос хэрэгжиж эхэлсэн учир ойрын хугацаанд ийм үр дүн хүлээх боломжгүй.

УИХ-ын сонгуулийн хуулийн 53.4-т “жагсаалтаар нэр дэвшигч нь нам, эвслийн сонгуулийн сурталчилгаанд зориулан хандив өгч болох бөгөөд нэг нэр дэвшигчийн өгсөн хандивын хэмжээ нь энэ хуульд заасны дагуу тогтоосон нэр дэвшигчээс тойрогт зарцуулах зардлын хэмжээний дунджаас хэтрэхгүй байна” гэжээ. Энэ нь нэг талаас нам жагсаалтаар нэр дэвшигчдээс хэт их мөнгө шаардахаас сэргийлж хязгаарласан заалт мэт боловч нөгөө талаас тойрогт зарцуулах зардлын дээд хэмжээг хэрхэн тогтоосноос шалтгаалан сонгуулийн пассив эрхийн хэрэгжилтэд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэл бүхий зохицуулалт байна (Б.Энхжаргал, 2016). Үндэсний аудитын газраас 2024 оны УИХ-ын сонгуулийн 13 тойрогт нэр дэвшигчийн зардлын дээд хэмжээг тогтоосныг тооцож үзвэл нэр дэвшүүлэх босго 1,135,805,935.53 төгрөг болж болзошгүй байгаа нь анхаарал татаж байна. Олон улсын судлаачдын зөвлөснөөр улс төр дэх мөнгөний зохисгүй нөлөөг арилгахад нэр дэвшигчдийн хандивын хязгаарыг хуульд заасан хувь хүн, хуулийн этгээдээс авч болох хандивын дээд хязгаартай ижил түвшинд зохицуулах нь зүйтэй юм.

Хүснэгт 2. 2024 оны УИХ-ын ээлжит сонгуулийн 13 тойрогт нэр дэвшигчийн зарцуулж болох зардлын дээд хэмжээг тогтоосон байдал

Тойргийн дугаар	Нэр дэвшигчийн нийт зардал (төгрөгөөр)
1-р тойрог 9 мандаттай Архангай, Баянхонгор, Өвөрхангай	1,378,983,796.9
2-р тойрог 10 мандаттай Говь-Алтай, Завхан, Увс, Ховд	1,526,054,380.9
3-р тойрог 3 мандаттай Баян-Өлгий аймаг	1,058,746,682.1

Тойргийн дугаар	Нэр дэвшигчийн нийт зардал (төгрөгөөр)
4-р тойрог 8 мандаттай Булган, Орхон, Хөвсгөл	1,230,485,598.1
5-р тойрог 10 мандаттай Дархан-Уул, Сэлэнгэ, Төв	1,064,320,563.5
6-р тойрог 7 мандаттай Дорнод, Сүхбаатар, Хэнтий	1,164,854,766.7
7-р тойрог 7 мандаттай Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь	1,098,521,799.6
8-р тойрог 5 мандаттай Баянзүрх дүүрэг	1,164,541,061.2
9-р тойрог 3 мандаттай Баянгол дүүрэг	1,099,697,551.2
10-р тойрог 6 мандаттай Сүхбаатар, Чингэлтэй	894,773,229.1
11-р тойрог 5 мандаттай Сонгинохайрхан дүүрэг	968,576,569.5
12-р тойрог 3 мандаттай Хан-Уул дүүрэг	1,121,664,599.4
13-р тойрог 2 мандаттай Багануур, Багахангай, Налайх дүүргүүд	994,256,563.7

Эх сурвалж: Үндэсний аудитын газар
<https://audit.mn/?p=24776> (2024.2.29)

УИХ-ын сонгуулийн хуульд зааснаар хувь тэнцүүлэх аргаар 48 нэр дэвшигчийг тодруулахад сонгогчид нам, эвсэлд санал өгөх буюу намын жагсаалт хаалттай, намаас жагсаасан нэр дэвшигчдийн эрэмбэ хөдлөхгүй байхаар зохицуулсан байна (МУИХСтХ-ийн 59.4). *Намын жагсаалтад нэр дэвшигчдийн эрэмбийг хэрхэн тогтоох нь нэр дэвшигчдийг тодруулахтай ижил чухал асуудал бөгөөд үүнийг намууд дотоод журамдаа тодорхой тусгаж зохицуулах нь үл ойлголцол, маргаанаас сэргийлэх, намын дотоод ардчиллыг хангахад чухал ач холбогдолтой.* 2012 онд холимог тогтолцоогоор явуулсан

УИХ-ын сонгуулийн үеэр намын жагсаалтад нэр дэвшигчдийг эрэмбэлэхэд намдаа өгсөн хандивын хэмжээг үзүүлэлт болгох тохиолдол гарсан нь нэлээд маргаан, шүүмжлэл дагуулсныг эргэн санахад илүүдэхгүй. Зарим намын нэр дэвшигч СЕХ-нд нэр дэвшигчдийн жагсаалтыг хүргүүлэхдээ эрэмбийг дур мэдэн өөрчилсөн гэх шүүмжлэл ч яригдаж байв.

2020 оны сонгуулийн дараа нэр дэвшигчдийг тодруулах процессыг судлаачид шүүмжилснийг үзвэл: “намууд нэр дэвшигчийг тодруулах журамтай гэдэг боловч тэр нь тодорхойгүй, ил тод бус, нэр дэвшигчдийг тодруулах ажиллагаа хөшигний арын дүрэмгүй зодоон болоод удаж байна” гэжээ.

- МАН аймгийн намын хороодоос горилогчдын нэрсийг авч, Бага хурлаар хэлэлцдэг гэх авч үнэн хэрэгтээ “намын бодлого”-оор нэр дэвшигч тодорч Бага хурлаар хэлэлцэгддэг. “Намын бодлого” гэдэг нь намын дарга, удирдах зөвлөлийг дэмжсэн горилогч дэмжлэг авдаг. Дүрмээр Бага хурлын гишүүн нэр дэвших эрхтэй ч тодорхой шалгуур байдаггүй учир өглөө нь Бага хурлын гишүүн болоод өдөр нь нэр дэвших эрхээ авсан тохиолдлууд ч байна.
- АН-ын дүрмээр Үндэсний бодлогын хорооны гишүүн нэр дэвших эрхтэй. Гэвч нам сонгуульд нэр дэвшигчийг тодруулах хурлын өмнө болон үеэр ҮБХ-ны чөлөөт суудалд гишүүн элсүүлж нэр дэвшигчийг тодруулсан. Мөн намын зарим гишүүд нэр дэвшихийн тулд намдаа шахалт үзүүлсэн, ойлголцоогүй нь өөр намаас болон бие дааж дэвшсэн.

Нэр дэвшигчдэд тавих шалгуур нь:

- 1) Мөнгөтэй байх- Сонгуулийн мажоритар тогтолцоог олон жил ашиглаж ирсэн учир нь намыг санхүүжүүлэх, орон нутгийн намын хороог тэтгэсэн, гишүүдийг цалинжуулах, сонгуулийн зардлаа өөрөө босгох чадвартай нэр дэвшигч байх,
- 2) Удирдлагаас дэмжлэгтэй байх- Намын даргаас зөвшөөрөл авсан, удирдлагын төвшинд дэмжигдэх боломжтой улс төрч нэр дэвших мандатыг авч байна. Энэ нь намаас нэр дэвшигчийг тодруулах үйл явцыг хаалттай болгож байна. (Э.Гэрэлт-Од & Д.Бямбажав, 2020).

Цаашид нэр дэвшигчдийг тодруулахад баримтлах журмыг тогтоохдоо улс төр дэх мөнгөний зохисгүй нөлөө, улс төрийн хүрээний авлигын асуудлыг нийтээрээ эрс шүүмжилж, шударга ёсыг хүсэмжилж буй нийгмийн хэрэгцээ

шаардлагыг харгалзан намын дотоод ардчиллын энэ гажуудлыг засаж, 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн үзэл баримтлалын хүрээнд нийцүүлэх нь туйлын чухал байна.

ОЛОН УЛСЫН САЙН ТУРШЛАГА

Төрийн сонгуульд өрсөлдөх нэр дэвшигчдээ тодруулах намын дотоод сонгууль шударга зарчмаар явагдах нь дотоод ардчиллынх нь нэг чухал үзүүлэлт болно. Үүнд, юуны түрүүнд дүрэм журмаа гишүүдийн оролцоог ханган боловсруулж ягштал мөрдөх, өрсөлдөөнт процесс нь шударга зарчимд нийцсэн нээлттэй байх нь наад захын шалгуурууд болой. 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөс эхлэлтэй эрх зүйн орчны шинэчлэлийн хүрээнд намууд үйл ажиллагааны горим, дүрэм журмаа шинэчлэн сайжруулахад бусад ардчилсан оронд намууд нь дотоод сонгуулиа явуулж буй туршлагыг судлах нь ач холбогдолтой. Үүнд, ялангуяа намын хаалттай жагсаалтад нэр дэвшигчдийг эрэмбэлэх асуудлыг хэрхэн шийдвэрлэдэг зарим сайн туршлагыг судлах нь чухал гэж үзлээ.

Өрсөлдөөнт сонгуультай ардчилсан улсуудад 1960-аад оны сүүл хүртэл нэр дэвшигчдээ

тодруулж ирсэн процесс нь өнөөгийн манай намуудын дагаж ирсэн процесстой төстэй буюу намын доторх нөлөө бүхий цөөн хүний хүрээнд төвлөрсөн байдлаар шийддэг байсныг судлаачид тэмдэглэсэн байдаг (Олон улсын бүгд найрамдахчуудын хүрээлэн, 2022). Өнгөрсөн гуч гаруй жилийн хугацаанд намууд нэр дэвшигчдээ тодруулах процесс нь гишүүд болон сонгогчдод нээлттэй ардчилсан байдлаар явагдах болсон бөгөөд сүүлийн жилүүдэд технократ, хүний нөөцийн арга барилыг нэвтрүүлэх хандлага шинээр ажиглагдаж эхэлжээ.

Түүхийн явцад намууд дотоод сонгуулиа хэрхэн зохион байгуулж ирснийг ерөнхийд нь авч үзвэл үндсэн таван арга байх ба эдгээр нь төлөөллийг хангах, ардчилсан зарчимд нийцэх талаасаа харилцан адилгүй, тус тусын эерэг болон сул талуудтай байна.

Хүснэгт 3. Нэр дэвшигчдийг тодруулах үндсэн аргууд

Нэр дэвшигчийг тодруулах арга	Онцлог	Эерэг тал	Сул тал
Нээлттэй урьдчилсан сонгууль/ сонгон шалгаруулалт	<ul style="list-style-type: none"> - Зөвхөн намын гишүүн, дэмжигчдээр хязгаарлагдахгүй бүх сонгогч чөлөөтэй оролцох боломжтой - Сонгогчдын оролцоо өндөр байх нь намын легитим байдлыг бэхжүүлэх нөлөөтэй 	<ul style="list-style-type: none"> - Ил тод, оролцоог хангасан буюу ардчилсан процесс - Намын хувьд давхар сурталчилгаа болох бөгөөд энэ нь кампанит ажилд нь тустай 	<ul style="list-style-type: none"> - Намын зүгээс нэр дэвшигчдэдээ хяналт тавих хөшүүрэг суларна - Популист улс төрчид давамгайлах тал бий - Өрсөлдөгч намуудын зүгээс ялах магадлал багатай нэр дэвшигчдийг дэмжиж оролцох гэх мэтээр үр дүнд нөлөөлөх оролдлого гарах нь бий - Зохион байгуулалтын зардал ихтэй
Хаалттай урьдчилсан сонгууль/сонгон шалгаруулалт	<ul style="list-style-type: none"> - Эцсийн шийдвэрт намын даргын нөлөө өндөр - Зөвхөн намын гишүүд, дэмжигчид оролцох боломжтой 	<ul style="list-style-type: none"> - Намын гишүүдийн оролцоо түлхүү хангагдана 	<ul style="list-style-type: none"> - Нэр дэвшигчдийн хувьд сонгогчдоос хөндийрөх тал ажиглагдана - Намын дотор “санал хайрцаглах” “санал худалдан авах” гэх мэт чөлөөт, ардчилсан сонгуульд сөрөг нөлөөтэй үзэгдэл гарах нь бий

Нэр дэвшигчийг тодруулах арга	Онцлог	Эерэг тал	Сул тал
Хаалттай шийдвэр	<ul style="list-style-type: none"> - Намын дарга буюу хаалттай бүлгийн шийдвэр сонгон шалгаруулалтад гол үүрэгтэй - Хувь хүнээс хамаарах улс төр явагдах нөхцөл болно 	<ul style="list-style-type: none"> - Намын дарга процессыг бүхэлд нь хянан, намын сонгуулийн стратеги, тактикт тохируулан удирдах боломжтой 	<ul style="list-style-type: none"> - Улс төрийн клиентелизм газар авах байдал ажиглагдана
Технократ арга	<ul style="list-style-type: none"> - Мэргэжилтнүүдээс бүрдсэн бүтцээр дамжуулж хүний нөөцийн салбарын арга барил, зарчимд тулгуурласан сонгон шалгаруулалт явуулна 	<ul style="list-style-type: none"> - Ил тод - Процессын хувьд бүх талуудад ойлгомжтой 	<ul style="list-style-type: none"> - Гишүүдийн оролцоо хумигдах талтай
Холимог	<ul style="list-style-type: none"> - Мэргэжилтнүүд, намын бүтцийн байгууллагууд, тэдний төлөөлөл, сонгогчид гэх мэт олон талуудыг шат шатанд оролцуулсан сонгон шалгаруулалт 	<ul style="list-style-type: none"> - Сайтар зохион байгуулсан нөхцөлд олон талаар эерэг нөлөөтэй бөгөөд ардчилсан процесс 	<ul style="list-style-type: none"> - Хэт нүсэр, зохион байгуулалтын хувьд төвөгтэй болох талтай

Тухайлбал, урьдчилсан сонгууль (primary) буюу нээлттэй, хаалттай сонгон шалгаруулалтаар нэр дэвшигчдийг шалгаруулж сонгох нь оролцоо хангасан, нээлттэй үйл явц гэдэг утгаараа намын дотоод ардчилалд эерэг нөлөөтэй. Гэвч зохион байгуулалтын хувьд нэлээд нүсэр ажил болох тул ялангуяа шинэ намуудын хувьд амаргүй ажил байдаг.

Хэрэв амжилттай хэрэгжүүлж чадвал нээлттэй урьдчилсан сонгууль намын легитим байдлаа бэхжүүлж улмаар энэ нь сонгуульд ялалт байгуулахад голлох үүрэг гүйцэтгэдэг болохыг нотолсон тод жишээ нь 2012 оны Франц Улсын Ерөнхийлөгчийн сонгууль байдаг. Энэхүү сонгуульд ялалт байгуулсан Франц Холландын Социалист нам тус улсын түүхэнд анх удаа нээлттэй урьдчилсан сонгуулиар нэр дэвшигчээ тодруулсан нь тухайн үед өрсөлдөгч баруун-төвийн үзэл баримтлал бүхий намаас дахин сонгогдохоор өрсөлдөж байсан Ерөнхийлөгч асан Никола Саркозиг ялж гарч ирэхэд шийдвэрлэх нөлөө үзүүлсэн гэж судлаачид тэмдэглэсэн

байдаг (Музергес.Т, 2022). Социалист намын Ерөнхийлөгчид нэр дэвшигчээ тодруулах нээлттэй урьдчилсан сонгууль нь Франц Улсын Ерөнхийлөгчийн сонгуулиас зургаан сарын өмнө явагдсан байдаг ба үүнд тус улсын сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэлтэй бүх сонгогч оролцох боломжтой байв. Санал өгөх хүн 1 евро төлөхийн сацуу, тус намын үнэт зүйлийг дэмжиж буйгаа илэрхийлж гарын үсгээ зурсан ба эхний шатанд 2.6 сая хүн, хоёр дахь шатанд 2.8 сая хүн оролцсоноор сонгуулийн зардлаа бүрэн нөхөж чадсан түүхтэй.

Хүснэгтэд дурдсан таван аргаас холимог арга нь нэр дэвшигчийг тодруулах процесст нэг талаас гишүүдийн оролцоог хангах, нөгөө талаас намын бодлогын хүрээнд шийдвэр гаргах нөхцөлийг хангах зорилгыг гүйцэлдэхүйц өвөрмөц арга юм. Үүний жишээ нь Их Британийн Консерватив намын парламентын сонгуульд өрсөлдөх нэр дэвшигчдээ тодруулах процесс билээ. XX зуунд Их Британийн 20 Ерөнхий сайдын 12 нь Консерватив намынх байсан нь тус намын улс

төрд эзлэх жин, нэр дэвшигчдийнх нь чансааг илтгэх чухал үзүүлэлт болно. Нэр дэвшигчийг тодруулах процессыг авч үзвэл:

- Нэр дэвших сонирхолтой гишүүн нь Консерватив намын цахим хуудсанд байршуулсан маягтыг бөглөнө.
- Лондон хотод байрлах төв намаас нь сонирхлоо илэрхийлсэн этгээдэд өргөдлийн маягт илгээх бөгөөд үүнд хувийн зан чанар, туршлага, карьер, үнэт зүйл, Консерватив намын үзэл санаа, үйл хэрэгт үнэнч зүтгэх байдал зэргийг шалгах асуултууд багтсан байдаг.
- Сонирхлоо илэрхийсэн этгээд өргөдлийн маягтаа бөглөж ирүүлсний дараа нэр дэвших шалгуурыг хангаж байна гэж үзвэл Парламентын үнэлгээний зөвлөлийн (Parliamentary assessment board) шалгалтад оролцох урилга хүргүүлнэ. Үнэлгээ нь бүтэн өдөр үргэлжлэх бөгөөд үүнд ганцаарчилсан ярилцлага, олон нийтэд хандсан үг хэлэх шалгалт, хоёр эсээ, симуляци туршилт, багаар ажиллах чадварын шалгалт гэх мэт парламентын гишүүнд байвал зохих чадварыг эзэмшсэн эсэхийг шалгах үе шатуудтай байна. Шалгалтыг намын харъяа сайн дурын байгууллагаас томилсон гурван хүний бүрэлдэхүүнтэй баг зохион байгуулж, оролцогчдыг үнэлдэг. Зарим тохиолдолд парламентын гишүүд оролцох нь бий.
- Шалгалтыг давсан хүмүүс нэр дэвших эрх бүхий гишүүдийн жагсаалтад нэр нь бичигдэх бөгөөд аль ч тойрогт нэр дэвших боломжтой болдог байна. Үүгээр эхний шат дуусна.

Нэр дэвшигчийг тодруулах дараагийн шатанд намын орон нутаг дахь анхан шатны байгууллага гол үүрэг гүйцэтгэнэ. Үүнд, анхан шатны байгууллагын дарга, хоёр дэд дарга, хоёр гишүүнээс бүрдсэн хороо нэр дэвшигчдээс ирүүлсэн материалыг хянан дараагийн шалгаруулалтад оролцох хүмүүсийг

тодруулдаг.⁶ Энэ шатанд шалгарсан хүмүүстэй намын анхан шатны нэгжийн удирдах зөвлөл нь нэг бүрчлэн ярилцлага хийнэ. Эндээс нэр дэвших боломжтой хоёр хүнийг шалгаруулах ба анхан шатны нэгжийн бүх гишүүдийн хуралдаанаар нууц санал хураалт явуулж эцсийн шийдвэрийг гаргадаг байна (Бөүви.А, 2022).

Нам сонгуульд өрсөлдөх нэр дэвшигчдээ тодруулах процесст сүүлийн үед нэлээд газар авч буй хандлага нь технократ арга юм. 2014 оны сонгуульд ялагдал хүлээсний дараа нэр дэвшигчдээ тодруулах процессоо шинэчилж, улмаар 2019 онд ялалт байгуулсан Грек Улсын эрх баригч Шинэ Ардчилсан намын туршлага сонирхолтой жишээ болно. Улс төрд шинэ нүүр царай, чадвартай хүмүүс дутагдаж байгааг соргог мэдэрсэн тус намын дарга Кириаκος Мицотакис мерит зарчим буюу чадахуйн зарчимд тулгуурласан шинэлэг процессоор нэр дэвшигчдээ тодруулах шийдэл гаргасан байдаг. Энэ хүрээнд 25-50 насны, олон салбарын төлөөлөл болсон, басхүү чадвар туршлагаараа салбараа тэргүүлж буй шинэ хүмүүсийг татахыг зорьжээ. Улмаар хүн амын статистик, сонгуулийн өгөгдөл, намын бусад мэдээлэлд үндэслэн ялалт байгуулах магадлалтай нэр дэвшигч ямар шалгуурыг хангавал зохихыг хүний нөөцийн салбарт түгээмэл ашигладаг аргаар боловсруулж гаргасан байдаг. Нэр дэвших боломжтой хүмүүсийн жагсаалт бүрдүүлэхэд голлох үүрэг гүйцэтгэсэн арга нь нээлттэй, ил тод сонгон шалгаруулалт байв. Энэ нь нам нийгмээс тасарсан, иргэдийн амьдралыг ойлгохоо байсан гэх шүүмжлэлийг намжаахад нөлөө үзүүлсэн гэж судлаачид дүгнэсэн байдаг. Сонгон шалгаруулалт дараах үе шатаар явагдсан байдаг:

- **Цахим хуудсаар өргөдөл хүлээн авах:** үүнд, боловсрол, туршлага, мэргэшил, сонирхол, зорилго гэх мэт асуултууд багтсанаас гадна бусад асуултууд багтсан байв.
- **Өргөдөл гаргасан хүмүүсийн материалыг хянах:** төслийн зохицуулагчийн удирдсан

⁶ Таван гишүүнтэй хороонд дор хаяж нэг эмэгтэй, 30-с доош насны нэг хүн байх ёстой.

хүний нөөцийн туршлага бүхий мэргэжлийн баг ажиллаж урьдчилсан үнэлгээг гүйцэтгэжээ.

- **Эхний шатны ярилцлага:** Тус бүр гурван гишүүнтэй 12 баг ажиллаж сард 50 орчим ярилцлага хийх даалгавартай ажилласан байна. Багт ажиллах гурван хүний нэг нь хүний нөөцийн мэргэжилтэн, нөгөөх нь нэр хүнд бүхий судлаач/эрдэмтэн, харин 3 дах нь улс төрч байхаар зохион байгуулсан бөгөөд үнэлгээг ижил аргаар хийхэд онцгой анхаарч бүх гишүүдийг тусгай сургалтад хамруулсан байдаг.
- **Хоёр дахь шатны ярилцлага:** хамгийн өндөр оноо авсан хүмүүстэй төслийн зохицуулагч ярилцлага хийж зарим мэдээллийг тодруулахад чиглэсэн процесс байв.
- **Нэр дэвших боломжтой хүмүүсийн нэрсийг намын удирдлагад уламжлах:** тухайн нэр дэвшигч урьдчилж тодорхойлсон шалгуур тус бүрийг хэрхэн хангаж байгаа үндэслэл, үнэлгээний дүн, нийгмийн сүлжээнд идэвхтэй байдал, санхүү, гэмт хэрэгт холбогдож байсан эсэх, нийгэмд хэр нэр хүндтэй гэх мэт олон үзүүлэлтийг дэлгэрэнгүй багтаасан хувийн хэрэгт тулгуурлан намын даргад танилцуулсан байна.
- Сургалт, үнэлгээ/шалгалт, эцсийн шийдвэр

Энэ аргын хувьд өндөр мэдлэг, чадвартай хүмүүсээр “цус сэлбэх” боломж нээсэн ч намын гишүүдийн оролцоог хумих, нэр дэвшигчдийн жагсаалтад цөөнхийн төлөөллийг оруулж ирэхэд тохиромж багатай сул тал ажиглагдсаныг судлаачид шүүмжилсэн байдаг. Грек Улсын Шинэ Ардчилсан намын хувьд 10 нэр дэвшигч тутмын 8 нь эрэгтэй байв (Пизика.Р, 2022).

Эцэст нь 2024 оны УИХ-ын ээлжит сонгуульд оролцохоор бэлтгэлээ базааж буй Монголын улс төрийн намуудын хувьд гарцаагүй сонирхол

татах нэг асуудал нь намын жагсаалтаар нэр дэвшигчдийг хэрхэн тодруулж эрэмбэлэх тухай асуудал юм.

Шинэ Зеланд Улсын нэгэн намын нэрсийн жагсаалт гаргаж буй дүрмийг жишээ болгон авч үзье.⁷

Нам нь сонгууль болохоос гурван сарын өмнө тухайн сонгуульд нэр дэвшиж өрсөлдөхгүй, төвийг сахиж, даалгасан ажлыг чанартай гүйцэтгэхээ илэрхийлсэн намын гишүүдээс бүрдсэн Нэр дэвшигчдийг тодруулах, жагсаалтын эрэмбийг тогтоох хороо байгуулна. Энэхүү хорооны гишүүдийг чадвар, төвийг сахиж ажиллах чадавх буюу сонирхлын зөрчил гарах эрсдэл, намын гишүүдийн төлөөллийг хангах байдал зэргийг харгалзаж, намын гишүүдийн оролцоотой нээлттэй хэлэлцүүлгүүд явуулсны эцэст намын Удирдах зөвлөлөөс томилно.

Хороо нь эхлээд нэр дэвшигчид тавих шалгуурыг тогтоох ба үүнийг мөн Удирдах зөвлөл хэлэлцэн батална. Нэр дэвшихээр горилогчид нь нэр дэвшигчийн гарынавалгатай танилцан, сонирхлоо илэрхийлэх мэдэгдэлд гарын үсэг зурахын зэрэгцээ өөрийн үнэлгээний маягт бөглөнө. Нэр дэвшихийн тулд тухайн намын гишүүнээр дор хаяж зургаагаас доошгүй сар болсон, намын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож буй тав хүртэлх хүнээс өөрийг нь дэмжиж буй тодорхойлолт авах ёстой.

Нэр дэвших сонирхлоо илэрхийлэх зарыг намын нийт гишүүдэд хүргэнэ. Сонирхлоо илэрхийлсэн хүмүүсээс нэр дэвших боломжтой гишүүдийн жагсаалт үүсгэх ажлыг Хороо зохион байгуулах бөгөөд намаас тавьсан шалгуур хангах эсэх, хуульд заасан бусад шаардлага, үүнд гэмт хэрэгт холбогдоогүй байх гэх мэт шаардлагыг хангаж буй эсэхийг хянаж үздэг байна. Түүнчлэн жагсаалтад бүртгэхийн өмнө ярилцлага хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд удирдах зөвлөлийн гишүүнийг байлцуулна.

⁷ Шинэ Зеландын сонгуулийн хорооны цахим хуудаснаас тус улсын намуудын нэр дэвшигч тодруулах, жагсаалтын эрэмбэ тогтоох (Candidate selection and list ranking procedures) дүрмүүдийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг үзнэ үү. <https://elections.nz/assets/party-files/AJPANZ-Candidate-Selection-List-Ranking-Procedures.docx-1.pdf>

Намыг төлөөлж нийт гишүүдийн дуу хоолой болохоос гадна сонгуулийн амжилтаас шалтгаалж парламентын гишүүн болох магадлалтай тул жагсаалтад бүртгэгдсэн хүмүүсийг нарийн шалгууруудаар үнэлсний эцэст нэр дэвшигчээр сонгох боломжтой хүмүүсийн нэрийг удирдах зөвлөлд уламжилдаг бөгөөд хүн тус бүр дээр тодорхойлолт гарган танилцуулдаг.

Нэр дэвшигч нь:

- Манлайлах чадвар, багаар ажиллах туршлага
- Намын үзэл санааг үйлдлээр дэмжин ажиллах байдал
- Намын үнэт зүйлийг бусдад ухуулж ойлгуулах чадвар

ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Нэр дэвшигчийг тодруулах процесс нь сонгуулийн тогтолцооноос дутуугүй парламентын бүрэлдэхүүн, түүний төлөөллийн чадавхид шууд нөлөөтэй асуудал юм. Сонгуульд оролцох нэр дэвшигчдийг тодруулах үйл явц нь нэг талаас намын дотоод ардчиллыг хэмжих, нөгөө талаас засаглах чадавхыг нь шинжих үзүүлэлт болно. Дотооддоо ардчилалгүй нам ардчилсан засаглалыг хөгжүүлж чадах эсэх нь туйлын эргэлзээтэй гэж олон улсын судлаачид тэмдэглэсэн байдаг (Үндэсний ардчиллын хүрээлэн, 2005).

Намын дотоод ардчиллын асуудлыг авч үзэхэд намын удирдлага, нэр дэвшигчдийг тодруулж сонгох процесс, намын хөтөлбөр, бодлогын байр суурийг тодорхойлох үйл явц, эдгээрт 1) гишүүдийн болон бусад талын оролцоог ямар түвшинд хангаж буй, 2) шийдвэр гаргах тогтолцооны төвлөрсөн байдал болон 3) институтчлэл хэрхэн хангагдаж байгааг шинжилж үздэг. Өнөөг хүртэл улс төрд голлох үүрэг гүйцэтгэж ирсэн намуудын нэр дэвшигчдээ тодруулахад дагаж ирсэн процессыг дээрх хэмжүүрээр цэгнэж үзэхэд дотоод ардчилал туйлын дутагдалтай байгаа нь харагдаж байна.

2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд туссан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд УИХ-аас шинэчлэн

- Олон нийттэй харилцах чадвар
- Олон нийтийн дунд нэр хүндтэй байдал
- Намын кампанит ажлын арга зүй, стратеги, тактикийн талаарх мэдлэг
- Кампанит ажлын явцад багаар ажиллах чадамж

Жагсаалтыг бүрдүүлэх явцад хасагдсан намын гишүүн гомдол гаргах боломжтой бөгөөд үүнийг намын дотоод хяналтын байгууллага хянаж шийдвэрлэнэ. Жагсаалтаас нэр дэвшигчдийг сонгон, эрэмбэлэх ажлыг хороо нь Удирдах зөвлөлийн саналыг үндэслэн эрхлэн гүйцэтгэнэ. Энэхүү нэр дэвшигчдийн жагсаалтыг Удирдах зөвлөл нь хянан үзээд баталдаг.

баталсан Улс төрийн намын тухай хуульд зааснаар нэр дэвшигчийг тодруулах журмыг намын удирдах дээд байгууллага нь буюу бүх гишүүдээрээ хэлэлцэн батлах ёстойг тусгажээ. Энэ нь улс төрийн чухал шийдвэр гаргах журмыг намын гишүүдийн өргөн оролцоотой зөвшилцөж шийдвэрлэх нь дотоод ардчиллын зарчимд нийцнэ гэсэн санааг агуулж байна.

Журмын хүрээнд нэр дэвшигчдэд тавих шалгуурыг тогтоох, гишүүдэд сонгон шалгаруулалтад оролцох өргөдөл, хүсэлт гаргах журам, намын байгууллагын аль шатанд ямар бүрэлдэхүүн хянан үзэж нэр дэвших боломжтой гишүүдийн жагсаалт үүсгэх, сонгон шалгаруулах, эцэслэн шийдэх, тойрогт хуваарилах, намын жагсаалтад эрэмбэлэх, үүнд сонирхлын зөрчлөөс хэрхэн урьдчилан сэргийлэх, маргааныг шударгаар хянан шийдвэрлэх зэрэг олон чухал асуудлыг тусган шийдвэрлэх шаардлагатай. Ингэхдээ Үндсэн хуульд заасан намын дотоод үйл ажиллагаа ардчилсан зарчимд нийцсэн байх шаардлага болон Улс төрийн намын тухай хууль, сонгуулийн хууль тогтоомжид заасан шаардлагыг хангах нь чухал юм. Үүнд, улс төр дэх мөнгөний зохисгүй нөлөө, улс төрийн хүрээний авлигыг нийтээрээ эрс шүүмжилж, шударга ёсыг хүсэмжилж буй нийгмийн хэрэгцээ

шаардлагад хариу болохуйц, ардчилсан шударга зарчимд нийцүүлж тогтоох нь зүйтэй болохыг зөвлөж байна.

Журмыг боловсруулахад:

- Нэр дэвшигчдэд тавих шалгуур нь хуульд нийцсэн байхын сацуу, сонгогдох эрхийг хангахад чиглэсэн байх,
- Нэр дэвшигчдийг тодруулах процесс нь шударга, ардчилсан зарчимд нийцсэн, намын гишүүдэд хүртээмжтэй, оролцох боломжийг хангасан байх,

- Бүх түвшинд шийдвэр гаргахад оролцож буй талууд ашиг сонирхлын зөрчилгүй, зөвхөн дүрмийн хүрээнд шийдвэр гаргах нөхцөл, үндэслэлийг тодорхойлох,
- Нэр дэвшигчдийг тойрогт хуваарилах, намын жагсаалтын эрэмбийг тогтоох зэрэг шалгууруудыг аль болох нарийвчлан тусгах шаардлагатай.

Түүнчлэн, нэр дэвшигчдийг тодруулах процессын талаар намын гишүүд гомдол, маргаанаа дотоод хяналтын байгууллагадаа хандан шударгаар шийдвэрлүүлэх боломжтой байх зэрэг асуудлыг анхаарах нь зүйтэй гэж зөвлөж байна.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Бөүви, А. (2022). Их Британи дахь нэр дэвшигчдийг тодруулах процесс: Консерватив намын динамик аргачлал (Candidate (s)election in the United Kingdom: A dynamic approach for the Conservative Party). I. R. Institute-Д, *Олноос онцгойрох нь (Standing out from the Crowd) (хуудсд. 55-61).*

Музергес, Т. (2022). Франц дахь нэр дэвшигчдийг тодруулах процесс: Нээлттэй анхдагч сонгуулийг сонгосон болон холдсон урт түүх (Candidate (s)election in France: The long road toward (and away from) open primaries) . Т. I. Institute-Д, *Олноос онцгойрох нь /Standing out from the crowd/ (хуудсд. 32-42). Washington. DC.*

Пизика, Р. (2022). Candidate selection in Greece: A new professional approach for new democracy . I. R. Institute-Д, *Standing out from the Crowd.*

Рахат, Г. (2023). Нэр дэвшигчийг тодруулах аль арга хамгийн ардчилсан бэ? (Which Candidate Selection Method Is the Most Democratic?) *Government and Opposition*, 68–90.

АН. (2020). Ардчилсан намаас Улсын Их Хурал болон бүх шатны иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд нэр дэвшигчийг тодруулах журам .

Б.Энхжаргал. (2016 оны 4-р сарын 17). *Дэнчингийн мөнгийг дэнсэлье.* <https://ikon.mn/n/phz-ээс> Гаргасан

Бурчер, К. У., & Касал-Бертоа, Ф. (2018). *Монголын улс төрийн санхүүжилтийн эрх зүйн орчин: дүн шинжилгээ, санал зөвлөмж.* Улаанбаатар: Нээлттэй Нийгэм Форум; Ардчилал сонгуулийг дэмжих олон улсын хүрээлэн .

Э.Гэрэлт-Од. (2021 оны 3-р сарын 25). Монгол Улсад нэг нам давамгайлсан улс төрийн тогтолцоо бүрдэж байна. (www.medeem.mn)

Касал Бертоа, Ф., & А.Бат-Оргил. (2021). *Монголын улс төрийн намуудын институтчилэл.* Улаанбаатар: Фридрих-Эбертийн сан.

МАН. (2020 оны 3-р сарын 23). Монгол ардын намаас Монгол Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшүүлэх, санал хураалт явуулах, дүн гаргах журам. *МАН-ын Бага хурлын 06-р тогтоолын хавсралт.*

Олон улсын бүгд найрамдахчуудын хүрээлэн. (2022). Олноос онцгойрох нь */Standing out from the crowd/.*

Үндэсний ардчиллын хүрээлэн. (2005). *Улс төрийн намууд болон ардчилал: онол, практик (Political parties and democracy in theoretical and practical perspectives).* www.ndi.org: chrome-extension://efaidnbmnnnibpcajpcglclefindmkaj/https://www.ndi.org/sites/default/files/1951_polpart_scarrow_110105_5.pdf

Фиш, С., & Сиберг, М. (2017). Монголын ардчиллын далд түшиг (The secret supports of Mongolian democracy). *Journal of Democracy*, 129-143.

Цогц хөгжлийн үндэсний төв. (2021). *Улс төр дэх залуучууд болон эмэгтэйчүүдэд тулгамдаж буй сорилт бэрхшээл .*

Э.Гэрэлт-Од, & Д.Бямбажав. (2020 оны 9-р сарын 22). *Нэр дэвшигчдийг тодруулах үйл явц хаалттай байсаар байх уу?* www.ikon.mn: <https://ikon.mn/opinion/1zpw>